



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

О.Уянгыг сургалтад хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тайваны Олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн сангаас 2019 оны 07 дугаар сарын 16-наас 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Хил дамнасан цахим худалдаа” сэдэвт сургалтад Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Отгонбаярын Уянгыг хамруулсугай.

2. О.Уянгад дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. О.Уянгын ажлыг орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох мэргэжилтэнд хариуцуулж, эзгүй байх хугацаанд нь ажил үүргийн хэрэгжилтэд биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэчимэгт даалгасугай.

4. Сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, санхүүгийн хэлтэст ирүүлэхийг мэргэжилтэн О.Уянгад даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

